

ТАВЬТЫН ӨВӨЛЖӨӨНИЙ ЭРТНИЙ БИЧЭЭС

Ц.БАТТУЛГА¹, Ж.ЦАМБАГАРАВ²

¹МУИС, ШУС, Ази судлалын тэнхим, e-mail: centreturkicamongol@yahoo.com

²Хархорины музей, e-mail: tsambaa_kobe24@yahoo.com

ТҮҮЛХҮҮР ҮГ: Тавьтын өвөлжөө, руни бичиг, Ху ЯньСи (Ши) бичив

ТОВЧ АГУУЛГА: 2015 онд Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын Шарга багийн нутаг Тавьтын өвөлжөө хэмээх газраас илрүүлсэн дөрвөн мөр руни бичээсийг уншиж тайлсан судалгааны үр дүнг толилуулж байгаа болно.

Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын Шарга багийн нутаг Тавьтын өвөлжөө хэмээх нэгэн өвөлжөөний хойд талын хадан цохионд руни бичээс буй ажээ (N 46°28'02,2'' E 102° 45' 26,2''; 1839 м). Уг бичээсийг хадны үе дамжуулан дөрвөн мөрөөр бичжээ. Үүнд, эхний хоёр мөрийг хадны үеийг дагуулан маш тод сийлж, харин доод хоёр мөрийг нэг хаднаа шахаж бичсэн байна (Зураг 1).

Нэгдүгээр мөрийн урт 36 см, үсгийн өндөр 10 см, хоёрдугаар мөрийн урт 35 см, үсгийн өндөр 10 см, гуравдугаар мөрийн урт 24 см, үсгийн өндөр 10 см, дөрөвдүгээр мөрийн урт 62 см, үсгийн өндөр 10 см. Гуравдугаар мөрийн төгсгөлийн үсэг эмтэрч унажээ. Бичээс бүхий том цохионы баруун урд талын доод хэсэгт иштэй онги, түүний баруун талд янгир тамга тус тус сийлсэн байна.

Бичээсийн эхийн сийрүүлгэ:

ᠠᠶᠠᠨ .1

ᠮᠦᠨ .2

[ᠮ]ᠬᠢᠭ .3

ᠮᠮᠮᠮᠮᠮ .4

Үсгийн галиг:

1. siklp

2. uQ(oQ)jn

3. btd[m]

4. YLmQYaQa

Үгийн галиг:

1. si kälip

2. qu yän

3. bitd[im]

4. yalim qayaqa

Дөрвөн мөр бичээсийн эхний хоёр мөрийг үелж тогтсон хаднаа тус тусад нь, харин гурав, дөрөвдүгээр мөрийг нэг хаднаа бичсэн байна. Чингэхдээ нэгдүгээр мөрийн хоёр үгийг үелж тогтсон нарийн хаднаа, үргэлжлүүлэн хоёрдугаар мөрийг бичихдээ түүний яг дээр буй харьцангуй зузаан хуудсан хаднаа тус тус бичсэн байна. Нэг, хоёрдугаар бичээс бүхий хуудсан хадны доор харьцангуй өргөн том талбайтай хаданд гурав, дөрөвдүгээр мөрийг бичсэн байх бөгөөд гуравдугаар мөрийг бичиж дуусахад түүний доор бичиг бичих талбай үлдээгүй тул гуравдугаар мөрийн дээр дөрөвдүгээр мөрийг сийлсэн бололтой.

Өөрөөр хэлбэл нэг, хоёрдугаар мөрийн байрыг, гурав, дөрөвдүгээр мөрийн байрыг тус тус сольж сийлсэн тул хаданд сийлэгдсэн дарааллаар уг бичээсийг унших боломжгүй юм.

Тиймээс бичээсийг зөв дараалалд оруулж сийрүүлбэл:

1. qu yän

2. si kälip

3. yalim qayaqa

4. bitdi[m]

Монгол хэлнээ орчуулбал:

1. Ху Янь
2. Си (Ши) ирж
3. эгц хаднаа
4. бичив би

Нэгтгэн үзвэл, “Ху Янь Си ирж эгц хаднаа бичив би” гэсэн утгатай болох нь тодорхой байна.



Зураг 1. Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын Шарга багийн нутаг Тавьтын өвөлжөө хэмээх газраас олдсон руни бичээс

Хэдийгээр уг бичээсэнд түүхэн үйл явдалд холбогдох чухал мэдээ сэлт байхгүй боловч Монгол нутгаас илрүүлсэн зарим бичээсийн үг, уншлагыг тодруулахад эх сурвалж болохын хувьд ач холбогдолтой юм. Жишээ нь, бичээснээ тэмдэглэгдсэн эгц, элгэн хад гэсэн утгатай $\gg\text{J}\text{D}$ *yalim* гэх үг Говь-Алтай аймгийн Бигэр сумын нутагт орших Бичигтийн бууцнаа (Баттулга 2008: 71-82; 2013: 131-138; Battulga 2013) мөн буй бөгөөд энэ нь тухайн үед “ HX $\text{J}\text{H}\text{J}\text{D}\text{H}\gg\text{J}\text{D}$ *yalim qayaqa bit* - “эгц хаднаа, элгэн хаднаа бич-бичих” гэх тогтсон хэллэг буюу бичээсийг ямар хаднаа бичсэнийг тодотгож дурддаг байсны нэгэн өчүүхэн баримт хэмээн үзэж болно.

Уг бичээсийг бичигч, Тан улсад хүчин зүтгэж нангиад овог нэр (цол хэргэм Ц.Б) авсан нүүдэлчин гаралтай Ху Янь Си хэмээгчийн талаар, тухайлаад Тан улсад дагаар орж “ху” овог авагсдын талаар цаашид судлууштайг тэмдэглэе.

НОМ ЗҮЙ

- Баттулга Ц.*, 2008. Бигэрийн эртний бичээсүүд, - *Хэл зохиол судлал*, Том.1(33), fasc.8. Улаанбаатар.
- Battulga Tsend*, 2013. Runic inscription in Biger. - *Türk kültürünü Araştırma Enstitüsü, Türk Kültürü Araştırmaları Armağan Dizisi 09*, Ankara.

ABSTRACT

TS.BATTULGA, J.TSAMBAGARAV

RUNIC INSCRIPTION AT THE TAVITYN UVULJOO, CENTRAL MONGOLIA

A runic inscription is found on the rock near winter camp called Tavityn uvuljuu, in Sharga bag, Nariinteel sum, Uvurkhangai province, Central Mongolia. The inscription is written in four lines on the several rock layers. The authors of the paper describe the meaning of the inscription as “*Qu yän si came here and wrote it*”.